



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.6, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын 5.4 дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Хүний нөөцийг 2010 - 2014 онд хөгжүүлэх бодлого”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үнэлгээний дүнг 2015 оны 3 дугаар улиралд удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ХШҮДАГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Оюунсүрэнд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-д даалгасугай.

САЙД




Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

081124

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 19 өдрийн
320 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Э. Оюунсүрэн, ХШҮДАГ-ын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Нарийн бичгийн дарга:

Р.Байгалмаа, Хяналт-шинжилгээ үнэлгээ,
дотоод аудитын газрын мэргэжилтэн

Гишүүд:

С.Эрдэнэтуяа, Стратеги бодлого
төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

С.Отгонсүх, Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын мэргэжилтэн

Б.Чулуунбат, Хяналт-шинжилгээ үнэлгээ,
дотоод аудитын газрын мэргэжилтэн

Г.Базархүрэл, Хяналт-шинжилгээ үнэлгээ,
дотоод аудитын газрын мэргэжилтэн

Д.Нарангэрэл, Эрүүл мэндийн хөгжлийн
төвийн мэргэжилтэн

Д.Уранчимэг, Эрүүл мэндийн хөгжлийн
төвийн албаны дарга

С.Дуламсүрэн, “Шинэ нийгмийн эрүүл
мэнд” Төрийн бус байгууллагын тэргүүн
/Зөвшилцсөнөөр/

Г.Баянжаргалан, Эрүүл мэндийн
удирдлагын мэргэжлийн салбар
зөвлөлийн нарийн бичгийн дарга
/Зөвшилцсөнөөр/

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 08 сарын 19 өдрийн
320 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

“ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ 2010 – 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ УДИРДАМЖ.

Үндэслэл:

“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010 - 2014 онд хөгжүүлэх бодлого” – батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2009 оны 12 дугаар сарын 28 ны 443 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах

Зорилго:

“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010 -2014 онд хөгжүүлэх бодлого”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн багийн үйл ажилагааны дүгнэлтийг нэгтгэх, дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал, зөвлөмж дэвшүүлэх

Үйл ажиллагааны чиглэл:

“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010 -2014 онд хөгжүүлэх бодлого”-ын төгсгөлийн үнэлгээг дараах чиглэлээр гүйцэтгэнэ.

- Бодлогын хэрэгжилтэд үнэлгээ хийхээр 2014 онд Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулсан ажлын хэсгийн гүйцэтгэсэн үнэлгээ дүгнэлтийг нэгтгэх, тодруулах асуудлуудыг нэмэлтээр судлах, үнэлгээ дүгнэлт өгөх
- Бодлогын шалгуур үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээ өгөх
- Бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарсан холбогдох эрх зүйн шийдвэрүүдийн биелэлтэд үнэлгээ өгөх
- Хамтран ажилласан байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны байдалд дүн шинжилгээ хийх
- Нэмэлт шаардлагатай мэдээллүүдийг холбогдох байгууллагуудаас гаргуулан авна.

Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллаганы төлөвлөгөө болон бусад холбогдох материалд үндэслэн тоон болон чанарын үзүүлэлтэд үнэлгээ өгнө.

Хамрах хүрээ:

- Эрүүл мэнд, спортын яамны Төрийн захиргаа удирдлагын газар, Стратеги бодлого төлөвлөлтийн газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, сонгогдсон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, өрх, сумын эрүүл мэндийн төвийн үнэлгээ өгөгдсөн материалуудыг ашиглах

Ажиллах бүрэлдэхүүн:

Эрүүл мэнд, спортын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар, Төрийн захиргаа удирдлагын газар, Стратеги бодлого төлөвлөлтийн газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Эрүүл мэндийн хөгжлийн төв, АШУУИС-ын судалгааны баг

Зохион байгуулагч:

Эрүүл мэнд спортын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

Хугацаа:

2015 оны 3,4 дүгээр улирал

Хүрэх үр дүн:

“Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2010 -2014 онд хөгжүүлэх бодлогын ”-ын төгсгөлийн үнэлгээний дүн гарч, дүнг Эрүүл мэнд, спортын яамны удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.